


13

Дуу чимээ



Чанга дуу чимээ нь сонсгол муудахын шалтгаан болдог. Дуу чимээ хэр чанга байна, хэр их, мөн хэр удаан өртөж байгаагаас таны сонсголыг хэр их гэмтээх нь хамаардаг. Мөн дуу чимээ сонсох байдал өөрчлөгдөж болно. Ингэснээр дуу чимээ тааламжтай биш болох эсвэл бодит байдлаасаа чанга болох мэт сонсогдоно.

Ажил олгогч нь ажилчдын сонсголыг хамгаалах үүрэгтэй:


- Ажилд авч, ажиллуулж эхлэхээс өмнө ажилчдын сонсголыг шалга;
- Ажлын дуу чимээний түвшинг шалга;
- Дуу чимээг багасган өөрчил;
- Ажилчдад сөргөөр нөлөөлөх дуу чимээний түвшинтэй байгаа бол чихний бөглөө, чихэвчээр ханга;

Дуу чимээнээс шалтгаалсан эрүүл мэндийн асуудлууд

Түр хугацаагаар сонсголгүй болох: Магадгүй их дуу чимээтэй газар байхдаа сонсголын тодорхой хэсгээ алдаж болох юм. Тухайн газраас явсны дараа хэсэг хугацаанд таны чих дүнгэнэж эсвэл тогтмол дуу чимээ сонсож байгаа юм шиг болох ба үүнийг чих шуугих гэнэ. Чанга дуу чимээнээс хол байвал эдгээр асуудал байхгүй болно. Гэвч чанга дуу чимээтэй газар олон цагийг өнгөрөөх нь асуудлыг илүү муутгаж, байнгын сонсголын асуудалтай болох болно.

Сонголоо бүрэн алдах: Хэрэв үргэлжлүүлэн чанга дуу чимээтэй орчинд ажилласаар байвал түр зуурын сонсголын асуудал даамжирч сонголоо бүрэн алдахад хүрнэ. Түүнчлэн хөгшрөх тусам бидний сонсгол байгалийн жамаар муудаж байдаг. Өдөр бүр чанга дуу чимээтэй газар ажилладаг бол сонголоо алдах явц илүү хурдан болно. Тэсрэлт, дэлбэрэлт зэрэг хэт чанга дуу чимээ нь сонсолыг тэр даруй гэмтээж, сонголоо бүрэн алдах шалтгаан болдог.

Эрүүл мэндийн бусад асуудал: ядрах, толгой өвдөх, стресстэх, үр зулбах, цусны даралт ихсэх, зүрх судасны өвчин, булчин зангирах, гэдэс дотор эвгүйрхэх, мөн толгой эргэх зэрэг эрүүл мэндийн бусад асуудлын шалтгаан нь мөн л чанга дуу чимээнээс болдог.



Дуу чимээтэй үйлдвэрт ажилласнаас болж Тянягийн сонсгол муудсан. Одоо эргэн тойронд нь чимээтэй үед ярианд оролцож чадахгүй, мөн охиныхоо зөөлөн дууг ч сонсоход хүндрэлтэй болсон.

Сонголоо алдахын эсрэг эвлэлдэн нэгдэх

Индонезийн Батам арал нь экспортын томоохон бүс. Том жижиг олон үйлдвэрт дэлхийн хамгийн том брэндүүд болох Филипс, Панасоник зэрэг электрон барааг үйлдвэрлэдэг.

Гэхдээ бусад электрон бараа үйлдвэрлэгч газруудыг бодвол электроникийн үйлдвэрийн ажилчид Батамын үйлдвэрчний эвлэлд нэгдэж чаддаг юм. Электроникийн компаниуд үйлдвэрчний эвлэл нь үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг гэдэг ч Батамын ажилчид зохистой цалин хөлс авч, хүндэтгэл нэр төртэйгөөр ажиллаж байгаа үед бүгд ялна гэдгийг харуулжээ. Энэ эвлэлийг “шар” эвлэл гэж нэрлэдэг ба ажилчид нь засгийн газар, ажил олгогчдод шаардлага тавьдаг юм. Энэ бол бодит бөгөөд ардчилсан, ажилчид өөрсдөө удирддаг эвлэл юм.

Анхандаа Батамын эвлэл нь ажилчдын цалин хөлс, ашиг орлогод анхаарлаа хандуулж байв. Гэвч тэд удалгүй эрүүл мэнд, ялангуяа дуу чимээнд өртөж байгааг зогсоох нь ямар чухал болохыг ойлгосон юм. FSPMI (Индонезийн төмрийн ажилчдын үйлдвэрчний эвлэл, дэлхийн үйлдвэрчний холбооны хэсэг) холбоо нь Батамтай нэгдсэнээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төлөө хүчтэй тэмцэгчид болжээ.

FSPMI нь чанга яригч шалгадаг ажилчдын сонсгол муудсанаас эхлэн дуу чимээний эсрэг үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Энэ холбоо нь ажил мэргэжил, эрүүл мэндийн асуудал хариуцсан газраас хэрхэн дуу чимээг хэмжих, хэрхэн сонсголгүй болохоос урьдчилан сэргийлэх талаар зааж өгөхийг хүссэн юм. Тэд аудиометр авч сонсгол алдалтыг хэмжиж сурчээ. Тэд холбооны уулзалтын үеэр ажилчдын сонсголыг хэмжиж эхлэв. Ингэснээр зөвхөн чанга яригч шалгагчид төдийгүй олон ажилчин сонсголоо алдсан шинж тэмдэгтэй болохыг илрүүлэв. Зарим ажилчид бүр дүлий болсон байлаа.



Цалин хөлс чухал ч бидний эрүүл мэнд илүү чухал. Хэрвээ бид өөртэй болчихвол ажил хийж, цалин авч чадахгүй.

FSPMI-ынхан сонсох чадвараа аудиометрээр шалгуулсан дүнг авч шууд үйлдвэрийн эзэд рүү явцгаажээ. FSPMI-ынхан компанид дуу чимээгээ багасган, чихний бөглөө, чихэвч өгөх хэрэгтэй гэж хэлсэн байна. Түүнчлэн жил бүр ажилчдын сонсголыг шалгах ба ажилд авахаасаа өмнө шалгаж байхыг шаардсан юм. Мөн FSPMI-ынхан аль хэдийн сонсголгүй болж дүлийрсэн ажилчдад компани нөхөн олговор олгож, үүргээ биелүүлэхийг шаардлаа.


Ингээд компаниуд дуу чимээг багасгах, сонсгол алдалтаас хамгаалах хөтөлбөрөө эхлүүлжээ. Ажилчдын тэмцлийн үр дүнд чанга дуу чимээнээс болж сонсголоо алдах нь Индонезийн засгийн газрын олж тогтоосон цорын ганц ажил мэргэжилтэй холбоотой өвчин юм.

Дуу чимээ хэт чанга байгааг хэрхэн мэдэх вэ

Ажлын байрны дуу чимээ хэтэрхий чанга бөгөөд сонсгол гэмтээх хэмжээнд байгаагийн шинж тэмдгүүд:

- Алд хэрийн зайд хэн нэгэнтэй ярихын тулд хашхирч ярьдаг бол;
- Ажил дууссаны дараа сонсголын чадвар буурдаг боловч үйлдвэрээс хол явж амарсны дараа сонсгол гайгүй болдог бол;
- Ажлын өдрийн төгсгөлд чих дүнгэнэж, шуугьдаг бол.

Мөн та магадгүй сонсголоо тэр дороо алдаж байгаагаа мэдэрч болох юм. Ихэнх хүмүүс харилцан яриаг сонсоход хэцүү болж эхлэхэд сонсож чадахгүй болсноо анзаардаг. Ингэж сонсголоо алдсанаа мэдэх үед та аль хэдийн сонсох эрхтнээ бүрмөсөн гэмтээсэн байдаг.



Алд хэрийн зайтай байхад хэн нэгнийг сонсож чадахгүй байгаа бол дуу чимээ хэт их байна гэсэн үг.

Ажилчид дүлий болохыг хүлээлгүйгээр үйлдвэрийн дуу чимээг удирдлага нь ойлгож багасгах хэрэгтэй болдог. Мөн ажлын дуу чимээ, ажилчдын сонголыг тогтмол шалгаснаар аюултай байгааг хэмжилтийн түвшнээр баталж болно.

Дуу чимээг хэмжих

Дууны түвшин хэмжигч нь дууг зөөлнөөс чанга хүртэл түвшинд хэмждэг. Хэмжигчийн түвшинг “децибел” гэж нэрлэдэг. Ажлын байрны дуу чимээ 90 децибелээс дээш байх нь сонголд хор хөнөөлтэй. Үйлдвэрчний эвлэл, аль эсвэл даргадаа ажлын байрны дуу чимээг хэмжүүлэе гэж санал тавь.

Ажилчдын сонголыг шалгах

Аудиограмм гэдэг нь өндөр эсвэл нам, зөөлөн эсвэл чанга дууг сонсох чадварыг хэмжигч юм. Хэрэв ажилчдын сонголыг 6 сар тутам шалгаж чадвал сонгол муудаж байна уу, хэвийн байна уу гэдгийг хэмжиж чадна. Ажил дээрээ тогтмол чихний бөглөө хэрэглэдэг бол энэ нь таны сонголыг хангалттай хамгаалж чадаж байна уу гэдгийг харуулж чадна. Дуу чимээнээс болж сонсголгүй болох нь хөгширснөөс болж сонсголгүй болохоос өөр байдаг ба энэхүү хэмжилт нь сонсгол алдалт ажлаас болж байна уу, үгүй юу гэдгийг баталж чадна.

Үйлдвэрийг яаж илүү нам гүм болгох вэ

Хэдийгээр үйлдвэрийн тоног төхөөрөмж бүр тийм их дуу гаргадаггүй ч бүх тоног төхөөрөмж, хүмүүс нэг зэрэг ажиллах үед дуу чимээ нь их чанга болдог. Дараах хэд хэдэн аргаар үйлдвэрийг дуу чимээ багатай болгож болно.

Дуу багатай тоног төхөөрөмж хэрэглэх. Хуучин чимээ ихтэй тоног төхөөрөмжийг илүү дуу багатай шинэ тоног төхөөрөмжөөр солихыг даргаасаа хүс. Заримдаа хуучин тоног төхөөрөмжийг дуу багатай болгон өөрчилж болдог.

Дуу чимээ ихтэй тоног төхөөрөмжийг хайрцагт хийх. Тоног төхөөрөмжид зориулан гадуур нь хана хийх эсвэл хаалттай хайрцагт хийснээр дуу чимээг дотор нь хадгалж болно. Заримдаа тоног төхөөрөмжийн хамгийн дуу чимээ ихтэй хэсгийг тойруулан хайрцаглаж болно. Хана эсвэл хайрцаг нь дуу чимээ шингээх материал буюу үйс, резин, эсгий эсвэл хөөсөөр бүрэгдсэн байдаг.

Дуу чимээ тусгаарлагчтай өрөөнд тоног төхөөрөмжийг оруулах. Хэрвээ тийм ч сайн шийдэл олдохгүй бол чанга дуутай тоног төхөөрөмжийг дуу чимээ тусгаарлагчтай өрөөнд оруулснаар зөвхөн цөөхөн тооны ажилчид л дуу чимээнд өртөх болно. Тэдгээр ажилчид нь үргэлж чихний хамгаалалт хэрэглэж,

мөн тухайн өрөөнөөс гарч байх тогтмол завсарлагатай байх хэрэгтэй. Өрөөнд дуу чимээ хуримтлагдахаас сэргийлж дуу чимээ шингээгч материалаар ханаа бүрээрэй.




Дуу чимээ шингээх:

- **Хананд, тааз болон шаланд:** үйлдвэрийг тэр чигт нь илүү чимээ багатай болгохын тулд тааз, шал, хана болон ажлын хэсгүүдийг тусгаарлагч хавтан эсвэл дуу чимээ шингээдэг, дор хаяж 5 см зузаантай хөшгөөр бүр;
- **Төмөр гадаргуу дээр хийгддэг ажил, багаж хэрэгсэл:** резин булантай тэрэг, хогийн сав, бусад сав, мөн ажил хийдэг хэсгийн гадаргууг резинээр бүрснээр багаж хэрэгсэл, төмөр хэсгийг цохиход үүсэх дуу чимээг багасгана;
- **Агаараар ажилладаг багаж хэрэгсэл:** агаараар ажилладаг (даралтат) багаж хэрэгслийн гарах хавхлагийн хэсэгт дуу намсгагч хийснээр багаж хэрэгслийн агаарт гаргаж байгаа дуу чимээг багасгаж чадна.

Тоног төхөөрөмжийг сайтар засах. Тоног төхөөрөмж дуу чимээтэй


байгаа нь тос, тохируулга, засвар үйлчилгээ хэрэгтэй байгаа эсвэл зарим хэсэг нь элэгдсэнээс болсон байдаг. Тоног төхөөрөмжид тогтмол тохируулга, засвар үйлчилгээ хийснээр илүү дуу чимээтэй болохоос сэргийлдэг.



Сайн засвар үйлчилгээ, тохируулга нь тоног төхөөрөмжийг дуу чимээ багатай байлгана.

Хөгжмөө багасгах. Зарим үйлдвэрийн эзэд ажилчдаа хооронд нь яриулахгүй, илүү хурдан ажиллуулахын тулд их чанга хөгжим тавьдаг. Энэ нь ажлын байрны дуу чимээг улам нэмэгдүүлж, ажилчдын сонголд аюултай болгодог.

Бэрхшээлээ хуваалцах. Хэрэв тоног төхөөрөмжийг чимээ багатай болгож чадахгүй бол ажилчид ажлаа сольж хийж болох ба ингэснээр хэн ч дуу чимээтэй хэсэгт үргэлж байх хэрэггүй болно. Хэдий тийм ч энэ нь дуу чимээний асуудлыг шийдэх урт хугацааны сайн арга биш юм.



Чихээ хамгаалах

Дуу чимээтэй орчинд ажилладаг ажилчид чимээ шуугианаас хамгаалах чихэвч, чихний бөглөө хэрэглэх хэрэгтэй. Ингэснээр тоног төхөөрөмж дээр ажиллаж байх үед ажлын байрыг илүү чимээ багатай болгож, ажилчдын сонголыг хамгаална.

Чихэвч нь толгойд зөөлөн хүрч, чихийг тэр чигт нь бүрхсэн бол сайн хамгаалалт болно. Чихэвчийг тогтмол цэвэрлэж, таарахаа больж, дуу чимээнээс тусгаарлахаа болих үед нь сольж байх хэрэгтэй.

Нэг удаагийн хөөсөн чихний бөглөөний хэмжээ нь таарсан, чихэнд зөв хийсэн бол сонголыг хамгаалж чадна. Эдгээр нь чихэнд эвтэйхэн орохоор хангалттай жижиг, тэлэхдээ чихний нүхийг дүүргэж байх хэрэгтэй. Сонголоо хамгаалах талаар 355-357 дугаар хуудаснаас үзнэ үү.

Сонголын хамгаалалт нь мөн аюулын дохиолол эсвэл ирж буй машин тоног төхөөрөмжийн чимээг сонсохгүй болгодог. Тиймээс дуу чимээнээс чихээ бөглөж хамгаалж байснаас дуу чимээний эх үүсвэрийг арилгасан нь илүү үр дүнтэй байдаг.

